

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ  
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН  
“ТАЙЛАНГИЙН МАЯГТ”<sup>1</sup>

**НЭГ. Товч танилцуулга<sup>2</sup>**

Тус газрын Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн томилох тухай тушаалыг 2024.02.14-ний А/25 дугаар даргын тушаалаар баталж үйл ажиллагаагаа хэрэгжүүлж ажиллаж байгаад, бүтэц орон тоо шинэчлэн батлагдсантай холбоотой Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг 2025.08.26-ны А/145 дугаар даргын тушаалаар шинэчлэн байгуулж ажиллаж байна.

**ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар**

2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт<sup>3</sup>:

Байгууллагын албан хаагчдыг соён гэгээрүүлэх, ёс зүйн ойлголтыг төлөвшүүлэх зорилгоор дараах сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд: Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 29.1, 38.1.9, 55.3 дахь заалтууд, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9.1.3 дахь заалт, байгууллагын батлагдсан төлөвлөгөөг тус тус үндэслэн албан хаагчдад чиглэсэн сургалтыг зохион байгуулав.

Сургалтын зорилго нь албан хаагчдын харилцаа, хандлага, ёс зүйн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, хувь хүний хөгжлийг дэмжих, мөн Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад чиглэсэн болно. Уг сургалтыг 2025 оны 09 дүгээр сарын 16, 17-ны өдрүүдэд Байгалийн түүхийн музейн 3 дугаар давхарт зохион байгуулсан бөгөөд эхний өдрийн сургалтад нийт 89 албан хаагч хамрагдсанаас Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 9 албан хаагч, хоёр дахь өдрийн сургалтад нийт 74 албан хаагч хамрагдсанаас Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 4, Үндэсний геологийн албаны 4 албан хаагч тус тус оролцсон.

Сургалтыг Агентлагийн даргын баталсан хөтөлбөрийн дагуу “Хувь хүний харилцаа, хандлага”, “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Авлигын эсрэг хамтдаа” сэдвүүдийн хүрээнд зохион байгуулж, Көүч Лаб сургалтын байгууллагын мэргэжлийн болон зөвлөх сургагч багш нар хичээлийг удирдан явуулсан.

Мөн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Ёс зүйн дэд хороо, Төрийн албаны зөвлөлийн Ёс зүйн хороотой хамтран 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдөр “Төрийн албан хаагчийн ёс зүй ба эрүүл мэнд” сэдэвт сургалтыг зохион байгуулж, тус сургалтад АМГТГ-ын 9 албан хаагч оролцов. Сургалтыг Төрийн албаны зөвлөлийн Ёс зүйн хорооны гишүүн, анагаах ухааны доктор, дэд профессор, хууль зүйн ухааны магистр С.Цэрэнбат удирдан явуулсан.

2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/145 дугаар тушаалаар Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн, 8 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр томилсон ба дэд хорооны үйл ажиллагааг дэмжин чиглүүлж, удирдлагаар ханган ажиллаж байна.

<sup>1</sup> Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.

<sup>2</sup> Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

<sup>3</sup> Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.



### 2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Тус газрын төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын байгууллагын үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээг тогтоон хэвшүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн талаарх иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээллийг шийдвэрлэх чиг үүргийг Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ”-г мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажиллаж байна.

Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/145 дугаар тушаалаар Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн, 8 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр томилсон.

Тайлант хугацаанд Монгол Улсын Ёс зүйн хорооноос зохион байгуулсан “Төрийн албан дахь ёс зүйн зөрчил: иргэд болон төрийн албан хаагчдын санаа бодлыг тандах тоон болон чанарын судалгаа”-нд байгууллагын хэмжээнд оролцож, нийт 185 албан хаагч болон байгууллагын үйлчилгээ авсан иргэдийн дунд өгөгдөл цуглуулах ажлыг зохион байгуулан гүйцэтгэсэн.

Байгууллагын албан хаагчдыг соён гэгээрүүлэх, ёс зүйн ойлголтыг төлөвшүүлэх зорилгоор дараах сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд: Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 29.1, 38.1.9, 55.3 дахь заалтууд, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9.1.3 дахь заалт, байгууллагын батлагдсан төлөвлөгөөг тус тус үндэслэн албан хаагчдад чиглэсэн сургалтыг зохион байгуулав.

Сургалтын зорилго нь албан хаагчдын харилцаа, хандлага, ёс зүйн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, хувь хүний хөгжлийг дэмжих, мөн Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад чиглэсэн болно. Уг сургалтыг 2025 оны 09 дүгээр сарын 16, 17-ны өдрүүдэд Байгалийн түүхийн музейн 3 дугаар давхарт зохион байгуулсан бөгөөд эхний өдрийн сургалтад нийт 89 албан хаагч хамрагдсанаас Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 9 албан хаагч, хоёр дахь өдрийн сургалтад нийт 74 албан хаагч хамрагдсанаас Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 4, Үндэсний геологийн албаны 4 албан хаагч тус тус оролцсон.

Сургалтыг Агентлагийн даргын баталсан хөтөлбөрийн дагуу “Хувь хүний харилцаа, хандлага”, “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Авлигын эсрэг хамтдаа” сэдвүүдийн хүрээнд зохион байгуулж, Көүч Лаб сургалтын байгууллагын мэргэжлийн болон зөвлөх сургагч багш нар хичээлийг удирдан явуулсан.

Мөн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Ёс зүйн дэд хороо, Төрийн албаны зөвлөлийн Ёс зүйн хороотой хамтран 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдөр “Төрийн албан хаагчийн ёс зүй ба эрүүл мэнд” сэдэвт сургалтыг зохион байгуулж, тус сургалтад АМГТГ-ын 9 албан хаагч оролцов. Сургалтыг Төрийн албаны зөвлөлийн Ёс зүйн хорооны гишүүн, анагаах ухааны доктор, дэд профессор, хууль зүйн ухааны магистр С.Цэрэнбат удирдан явуулсан.

Түүнчлэн 2025 оны 11 дүгээр сарын 13, 14-ний өдрүүдэд Удирдлагын академийн Төрийн албаны сургуульд зохион байгуулагдсан “Ёс зүй, хүний эрх” сэдэвт 16 цагийн сургалтад Хүний нөөцийн мэргэжилтэн Б.Нямсайхан, Сургалт хариуцсан мэргэжилтэн Э.Сарнай нар хамрагдаж, сургалтад амжилттай хамрагдсан тухай гэрчилгээ авсан болно.

Гарсан үр дүн, ололт амжилт:

Бэрхшээл:

|                                                                                                                                                                                                                                                     |                                                                                         |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------|
| Тус газрын албан хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор ажлын байрны чиг үүргийн шинжилгээ хийсэн ба ёс зүйн сургалт зохион байгуулж нийт албан хаагчдыг хамруулснаар байгууллагын соёл болон албан хаагчдын харилцаанд эергээр нөлөөлсөн. | Тус газрын албан хаагчдын ажлын ачааллаас үүдэлтэй сэтгэл зүйн тогтворгүй байдал үүсэх. |
| Санал:                                                                                                                                                                                                                                              |                                                                                         |
|                                                                                                                                                                                                                                                     |                                                                                         |

**Шалгах хэсэг:**

- ☐ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☐ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ☐ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

**БАТАЛГААЖУУЛАЛТ:**

Томилох эрх бүхий албан тушаалтан

Дарга  
/Албан тушаал/

Гарын үсэг

П. Батбаатар  
/Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны дарга

БСДГ-ын дарга  
/Албан тушаал/

Гарын үсэг

Б. Тувшинжаргал  
/Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

Ахлах шрифтчин  
/Албан тушаал/

Гарын үсэг

М. Бондараг  
/Гарын үсгийн тайлал/

Огноо: 2026 оны 01 сарын 05